



САНГИЙН ЯАМ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ

(Улсын төсөв, Нийгмийн
даатгалын сангийн төсөв,
Эрүүл мэндийн даатгалын
сангийн төсөв, Үндэсний
баялгийн сангийн төсөв)

[Төсвийн тухай хуулиас:
8.3.4.санхүү, төсвийн
асуудал эрхэлсэн төрийн
захиргааны төв
байгууллага Засгийн
газрын баталсан жилийн
төсвийн хязгаарыг
төсвийн удирдамжийн
хамт жил бүрийн 7 дугаар
сарын 5-ны дотор
төсвийн ерөнхийлөн
захирагчид хүргүүлэх]

[Төсвийн удирдамж болон
төсөв бэлтгэх маягууд,
судалгааны хүснэгтүүд MS
Word болон MS Excel файл
хэлбэрээр Сангийн яамны
веб хуудсанд тавигдсан
болно]

[Холбоос линк](#)

АГУУЛГА

1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР.....	3
2. ТЕЗ НАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР.....	3
2.1 Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс:.....	3
2.2 Төсвийн орлогын санал боловсруулах:	3
2.3 Төсвийн урсгал зардлын санал боловсруулах.....	4
2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал боловсруулах:.....	5
2.5 Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх	7
2.6 Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах	9
2.7 Төсвийн ангилал.....	9
2.8 Төсвийн санал хүлээн авч хянах.....	12
3. ТӨСВИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	13
4. ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР	14
4.1 Төсвийн үндсэн маягт буюу ТМ-01	14
4.2 Төсвийн үндсэн маягтын нэмэлт буюу ТМ-01a.....	16
4.3 Төсвийн удирдамжид дагалдсан төсвийн маягтуудын товчоо.....	17
4.4 Бусад.....	17

1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР

Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг ДНБ-ий 30.9 хувь, нийт зарлагыг ДНБ-ий 32.9 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн алдагдлыг ДНБ-ий 2.0 хувь байхаар тус тус тогтоосонтой нийцүүлж “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн хязгаар”-ыг боловсрууллаа. *(Улсын төсөв, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн хязгаарын төслийг Сангийн сайдын албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү)*

2. ТЕЗ НАРЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР

2.1 Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс:

2.1.1 Төсвийн тухай хуульд 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр салбаруудын жилийн төсвийн төслийг олон нийтэд хэлэлцүүлж, хэлэлцүүлгээс гарсан шаардлага хангасан саналыг төсвийн төсөлд тусгах эрх зүйн зохицуулалттай болсны дагуу ТЕЗ нарын төсвийн саналын хялбаршуулсан танилцуулгыг бэлтгэх хавсралт файл нэмэгдсэн. *(Удирдамжийн 3-ыг харах)*

2.1.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Биеийн тамир спортын улсын хороонд туршиж байгаа Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн маягт, зааварчилгаа шинэчлэгдсэн. *(Удирдамжийн 2.3.5-ийг харах)*

2.2 Төсвийн орлогын санал боловсруулах:

Төсвийн орлогын төслийг боловсруулахад Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.1.2 дахь хэсэгт заасан шаардлагын дагуу төсвийн зарчмыг мөрдлөг болгож, эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэн боловсруулсан 2025 оны төсвийн орлогын санал, 2020-2023 оны гүйцэтгэл, 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэл болон хүлээгдэж буй гүйцэтгэлийн мэдээллийг баталгаажуулан хавсралтаар ирүүлнэ. Үүнд:

2.2.1 Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг аж ахуйн нэгж тус бүрээр тооцон ирүүлэх;

- 2.2.2 Навигацийн орлогын төлөвлөлтийг олон улсын нөхцөл байдал болон гадаад хүчин зүйлд үндэслэн боловсруулан төсвийн саналаа ирүүлэх;
- 2.2.3 Монгол Улсад зорчих гадаадын иргэдэд виз олгох улсын тэмдэгтийн хураамжийн орлогын саналыг өмнөх жилийн гүйцэтгэлд үндэслэн улс орон тус бүрээр тооцоолон ирүүлэх;
- 2.2.4 Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогын төсөөллийн саналыг орлогын ангилал, иргэн, хуулийн этгээд тус бүрээр боловсруулан ирүүлнэ.

2.3 Төсвийн урсгал зардлын санал боловсруулах

- 2.3.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх;
- 2.3.2. Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг **1.1_Төсвийн саналын маягт**-ын дагуу бэлтгэх (Бүх ТЕЗ нар нарийвчилсан зааварчилгааг энэхүү удирдамжийн 4.1 дахь хэсгээс харах);
- 2.3.3. Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо **1.2_ТМ-01а маягт бөглөх заавар** дагуу бэлтгэн ирүүлэх;
- 2.3.4. ТЕЗ нар өөрсдийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнг тодорхойлж, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг **1.1_Төсвийн саналын маягт** файл дахь **“ТМ-01а”** маягт ашиглан тодорхойлох. Маягт бөглөх зааврыг удирдамжийн хавсралт **1.2_ТМ-01а маягт бөглөх заавар** файлаас үзэх.
- 2.3.5. Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг туршиж байгаа ХНХЯ, ХХААХҮЯ, СоЯ, БТСУХ, БШУЯ-д төсвийн саналаа **2.1_ҮДСТ төсвийн саналын маягт_УТ** болон **2.2_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар_УТ** дагуу боловсруулна.
- 2.3.6. **Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ):** Монгол Улсын Засгийн газар холбогдох хууль тогтоомж, салбар дундын жендэрийн эрх тэгш байдлыг хангах 10 жилийн стратеги төлөвлөгөө, салбарын яамдын жендэрийн бодлогуудад тусгагдсан ЖМТ-ийн аргачлалыг төсвийн шинэчлэлийн нэг хэсэг болгон ЖМТ-ийг зарим сонгосон яамдад 2021 оноос туршиж эхэлсэн.
Энэхүү аргачлалыг боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбарын сонгосон хөтөлбөрүүдэд туршиж, 2023 оноос эрүүл мэндийн салбарыг нэмж хамруулаад байна. Цаашид бусад салбар, хөтөлбөрүүдийг ЖМТ-д үе шаттай хамруулах, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх, төсөвлөлтийн аргачлалыг боловсронгуй болгох, төсвийн процесст шаардлагатай өөрчлөлтийг хийх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, салбар

хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэргээр ЖМТ-г үндэсний түвшинд бүрэн нэвтрүүлэх зорилт тавьж байна.

ЖМТ нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн аажмаар явагдах үйл явц байх юм. Иймд ТЕЗ нараас дараах байдлаар санал авахаар төлөвлөж байна. Үүнд:

а/ ЖМТ-ийг туршин нэвтрүүлж байгаа БШУЯ, ХНХЯ, ЭМЯ-ны сонгосон хөтөлбөр, арга хэмжээний саналуудыг **5_ЖМТ асуулга ба төсвийн саналын маягт** хавсралтад заасан **ЖМТ-ТМ-03** маягтыг ашиглаж бэлтгэнэ.

б/ Жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт болон төсөвлөлтийг улсын бүх ТЕЗ нар төсвийн зарцуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах талаар өдөр тутмын ажлын нэг хэсэг болгохын тулд улсын салбаруудын чадавх болон туршлагыг үнэлж, бодит нөхцөл байдлыг тодруулах үүднээс улсын бүх ТЕЗ нараас **5_ЖМТ асуулга ба төсвийн саналын маягт** хавсралтад заасан **ЖМТ-НМ-01, ЖМТ-НМ-02** асуулга болон судалгааг бүрэн бөглөнө.

2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал боловсруулах:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2024 оны 7 дугаар сарын 25-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчийн албан тоотоор болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээр хүлээн авна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчид хөрөнгө оруулалтын төслийн саналаа бэлтгэхдээ цахим системд заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд энэ удирдамжид заасан шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

- 2.4.1 Төсвийн тухай хуулийн 6, 27, 28, 29, 29¹ болон 31 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8, 11 дүгээр зүйл, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам, 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар “Журам болон аргачлалд өөрчлөлт оруулах тухай” 2023

- оны А/264 дүгээр тушаалын дагуу төлөвлөж, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем www.publicinvestment.gov.mn болон албан бичгээр ирүүлэх;
- 2.4.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу улсын богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, тэдгээрийн зорилтыг хангахад чиглэсэн байх;
- 2.4.3 Сангийн сайдын 2023 оны А/264 дүгээр тушаалын дагуу, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр дараах байдлаар төслүүдийг төлөвлөнө:
- 2.4.3.1 төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтийн шаардлага хангасан шинээр хэрэгжүүлэх төслүүдэд төсвийн төсөлд тусгах үнэлгээг хийх, үр ашгийг тооцсон байх;
- 2.4.3.2 он дамжин хэрэгжих төслүүдэд дахин үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх;
- 2.4.3.3 салбарын бодлого, баримтлах зарчим болон төслүүдийн танилцуулга, мэдээлэл, судалгааг ирүүлэх;
- 2.4.3.4 тухайн салбар 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар ямар үр дүнд хүрэх талаарх үр дүн, үр ашгийг мэдээллийг ирүүлэх;
- 2.4.4 Төсвийн тухай хуулийн 14.2 дахь заалтын дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;
- 2.4.5 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтын дагуу шинээр эхлэх төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс 2025 онд санхүүжих дүн нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байх буюу 3 жилд багтаан санхүүжүүлж, дуусгахаар төлөвлөх;
- 2.4.6 Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөх;
- 2.4.7 Барилгын тухай хуулийн 15.2, 13.2 дахь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтын дагуу 2025 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан зураг төсөвтэй, газрын зөвшөөрөл гарсан байх, холбогдох материалыг цахим системд оруулсан байх;
- 2.4.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагддаг төслүүдийн задаргаа, холбогдох материалыг ирүүлэх;
- 2.4.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн улсын төсвийн урсгал зардалд үзүүлэх нөлөөллийн тооцоо, төсөл

хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны судалгаа, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын мэдээллийг Сангийн сайдын 295, А/264 дүгээр тушаалын дагуу хийж, цахим системд оруулсан байх;

- 2.4.10 Төсвийн тухай хуулийн 31.4 дэх заалтын дагуу нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй гэж тооцоолсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсвэл санхүүжилтийг бууруулах санал, тооцоог ирүүлэх;
- 2.4.11 Улсын болон салбарын бодлогын хүрээнд ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх;
- 2.4.12 Төсөл, арга хэмжээний нэр томьёо, байршил, хүчин чадал, хэмжих нэгж жигд, мөнгөн илэрхийллийг сая төгрөгөөр цахим системд оруулсан байх;
- 2.4.13 Төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгах нийт төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем /PIMIS/-ээс боловсруулж, цахим систем дэх маягтын дагуу нэгтгэн ирүүлсэн байх;
- 2.4.14 Концессын эргэн төлөлтийн санхүүжилтийг 2025 оноос тухайн салбарын асуудал эрхэлсэн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцад тусгах тул Эдийн засгийн хөгжлийн яамтай тооцоо нийлж, эргэн төлөлтийн саналаа ирүүлэх;
- 2.4.15 Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 дэх хэсэгт заасныг зөрчихгүй байхад анхаарч төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтыг саналаа үндэслэл, тооцоололтой боловсруулж ирүүлсэн байх.

2.5 Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2025 оны гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн саналаа боловсруулахдаа Засгийн газраас баталсан зарлагын хязгаар болон дунд хугацаанд зээл, тусламжид баримталж байгаа бодлого, чиглэлийг удирдлага болгон, 2024 оны 7 дугаар сарын 25-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчийн албан бичгээр ирүүлэх ба төсөл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.5.1 Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээ нь МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх ба салбарын хөгжлийн бодлого, чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа талаар, төслийн хүлээгдэж буй үр дүнгийн танилцуулгыг MS Word болон MS Power Point хэлбэрээр ирүүлэх;

- 2.5.2 Гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслийн саналыг **НМ-09, НМ-09-01** маягтуудад заасны дагуу бэлтгэх ба дараах мэдээллийг тусгана.
- 2.5.2.1 гадаадын зээл, тусламжаар 2025 онд хэрэгжих төслүүдийг төслийн эх үүсвэр тус бүрээр шилжих, дуусах болон шинэ төслийн ангиллаар гарган, танилцуулгын хамт ирүүлэх;
- 2.5.2.2 төслийн зардлыг урсгал, хөрөнгийн болон эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд хуваарилан тусгах бөгөөд эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын дагуу төсвийн төслийг бэлтгэх;
- 2.5.2.3 санхүүжилтийн эх үүсвэр хэсэгт гадаадын зээл, тусламж, орон нутгийн төсөв болон улсын төсвийн урсгал эсвэл хөрөнгийн эх үүсвэр зэрэг аль эх үүсвэрээр санхүүжихийг тодорхой ирүүлэх;
- 2.5.2.4 зээл, тусламжийн төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлын саналыг тусад нь тооцож ирүүлэх (**НМ-09** маягтын **3-5, 7-9,15-17** баганыг бөглөх);
- 2.5.3 Төслийн саналыг гэрээний үндсэн валют болон төгрөг гэсэн 2 дүнгээр боловсруулах ба үндсэн валютыг төгрөгт хөрвүүлэхдээ Монгол банкны 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хаалтын ханшаар тооцох;
- 2.5.4 Монголын тал хариуцахаар зээл, тусламжийн гэрээнд туссан хөрөнгийн болон урсгал зардлын саналыг 2.7.1-2.7.3-т зааснаар дэлгэрэнгүй гаргах ба хөгжлийн түнштэй байгуулсан зээл, тусламжийн гэрээнд монгол тал хариуцахаар туссан гэрээний холбогдох заалт, мэдээллийг хавсаргаж ирүүлэх (**НМ-09** маягтын **4,5, 8-12, 15-17** баганыг бөглөх);
- 2.5.5 Мөн гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн Монголын тал хариуцах 2025 оны хөрөнгө оруулалтын ажлын хувьд зураг төсөв, магадлалаар батлагдсан мэдээлэл ирүүлэх бөгөөд шилжин хэрэгжиж буй төслийн хувьд төсөвт өртөг, урьд онуудад авсан санхүүжилтийн мэдээллийг өссөн дүнгээр тусган ирүүлэх (**НМ-09** маягтын **10-12** баганыг бөглөх);
- 2.5.6 Дамжуулан зээлийн гэрээтэй болон гэрээ хийгдэх төслийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд тусган ирүүлэх ба холбогдох гэрээний хуулбарыг ирүүлэх;
- 2.5.7 Мөн гадаадын зээл, тусламжаар 2024 онд хэрэгжиж байгаа төслүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг **НМ-9** маягтаар ирүүлнэ. Энэ хүрээнд урсгал, хөрөнгө болон эргэн төлөгдөх зардлыг нийт дүнгээр гаргаж, төслийн үндсэн үйл ажиллагааны данс болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн данс тус бүрээр хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцсон байна (**НМ-09** маягтын **2-9** баганыг бөглөх);

2.5.8 Түүнчлэн төслийн хэрэгжилтийн явцын танилцуулга, 2024 оны хэрэгжилтэд учирсан асуудал, төслийн хүрсэн үр дүнгийн танилцуулгыг ирүүлнэ.

2.6 Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах

Төсвийн төлөвлөлтийн үйл явцыг Fiscal программаар дамжуулан авах ба 2025 оны төсвийн зарлагын саналыг онлайнд суурилсан FISCAL-B хувилбарыг ашиглаж Сангийн яаманд ирүүлнэ. Системд өгөгдөл оруулах зааварчилгааг энэхүү удирдамжид хавсаргасан **3_Fiscal-B гарын авлага** файлаас харна уу. Программд өгөгдөл оруулахтай холбоотой тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын зөвлөх Ш.Оюунбаатар oyunbaatar@mof.gov.mn хаягаар болон **51-265753** утсаар лавлана уу.

2.7 Төсвийн ангилал

Төсвийн төслийг эдийн засгийн, хөтөлбөрийн болон зориулалт, арга хэмжээний ангиллыг 2015 оны Сангийн Сайдын 7-р тушаалаар батлагдсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”-ын дагуу боловсруулах бөгөөд төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг 2020 оны Сангийн сайдын 190-р тушаалаар баталсан “Заавар батлах тухай”-ыг баримтлан төлөвлөж ирүүлэх;

2.7.1 Төсвийн хуваарилалтын үр ашиг, үр дүнг сайжруулах зорилгоор зарим салбарын хөтөлбөр болон зориулалт-арга хэмжээний ангилалд дараах зүйлсийг шинээр нэмсэн. Үүнд:

1/ Хөтөлбөрийн ангилалд:

Хүснэгт 1. Шинэ хөтөлбөрийн ангилал

Хөтөлбөрийн нэр	Код	Тодорхойлолт
Соёл урлаг		
Соёлын өв	71706	Соёлын биет болон биет бус өвийн хамгаалал, хөгжил, сурталчилгаа, соёлын өвийн эрдэм шинжилгээ, судалгаатай холбоотой улс, орон нутгийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсөв, зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа
Соёлын бүтээлч үйлдвэрлэл	71707	Үндэсний соёлын агуулга бүхий бүтээгдэхүүн, контент үйлдвэрлэл, соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд үзүүлэх дэмжлэг үзүүлэхтэй холбоотой улс, орон нутгийн урсгал болон хөрөнгө оруулалтын төсөв, зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

2/ Зориулалт-арга хэмжээний ангилалд:

Хүснэгт 2. Шинэ зориулалт арга хэмжээний ангилал

Арга хэмжээний нэр	Код	Тодорхойлолт
Боловсрол:		
Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	81861	Хичээлийн бус цагаар явуулах сургалтын үйл ажиллагаа буюу танхимын бус сургалтын үйл ажиллагаа буюу музей, номын сан, түүхийн дурсгалт газарт түшиглэн танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх
Ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө	81862	Суралцагчийг ажил мэргэжлийн дэлгэрэнгүй мэдээллээр хангах, сургалт явуулах, ажлын байранд зуучлах, ажлын байрны мэдээллээр хангах үйл ажиллагаа
Уралдаан, тэмцээн	81863	Суралцагчдын авьяас, чадвар, сонирхлыг хөгжүүлэх, уралдаан тэмцээнд бэлтгэх, зохион байгуулах, оролцох, оролцогчдыг шагнах, урамшуулах ажлыг асран хамгаалагч, орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх	81864	Мэргэжлийн болон техникийн сургуулийн суралцагчдыг мэргэжлийн ур чадварын олон улсын хэмжээний тэмцээнд бэлтгэх, оролцох, урамшуулах, мөн үндэсний хэмжээний мэргэжлийн ур чадварын тэмцээнд бэлтгэх, зохион байгуулах, “ур чадварын үндэсний систем” хөгжүүлэх үйл ажиллагаа
Залуучууд, насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих	81865	Залуучууд, насанд хүрсэн хүн амд боловсрол, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, бүх төрлийн боловсрол нөхөн эзэмшүүлэх, үргэлжлүүлэх чиглэлээр олон нийт, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
Үнэлгээ, тест, шалгалт	81866	Сурлагын ахицыг тодорхой давтамжтайгаар үнэлэх, суралцагчдын сурлагын үр дүн, явцын ахицыг үнэлэх үнэлгээ, шалгалт, тест авах ажлыг бэлтгэх, төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрийн үр дүнг шинжлэх, үр дүнг танилцуулах, зөвлөмж өгөх, туслах, хамтрах үйл ажиллагаа.
Их дээд сургуулиудад олгох дэмжлэг	81867	Их, дээд сургуульд улсын болон орон нутгийн төсвөөс олгох татаас. Үүнд судалгаа, хөгжүүлэлтийн татаас орно. Грант орохгүй. Хөгжмийн дээд боловсролын байгууллагад олгох нэмэлт санхүүжилт, мөн Түшиц эмнэгт олгох татаас, Монгол-Германы хамтарсан сургуульд олгох санхүүжилт /Үүнтэй холбогдуулан 81856, 80415 кодтой арга хэмжээн дээр төсөв оруулахгүй байх/
Засгийн газраас гадаадад магистр, доктороор суралцах оюутанд олгох тэтгэлэг	81868	Засгийн газраас гадаадын шилдэг их, дээд сургуульд суралцах оюутанд олгох тэтгэлэг.
Хөгжлийн бэрхшээлттэй суралцагчид олгох буцалтгүй тусламж	81869	Хөгжлийн бэрхшээлттэй Монгол улсын иргэнд гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцахад олгох буцалтгүй тусламж.

Эрэлттэй мэргэжлээр дотоодод суралцах тэтгэлэг	81870	Нийгмийн салбарын зарим эрэлттэй мэргэжил-хэл засалч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, сэтгэл зүйч, аргагүйч зэрэг ажил мэргэжлээр дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагчид олгох тэтгэлэг.
Эрэлттэй мэргэжлийн гадаадад суралцах бакалаврын тэтгэлэг	81871	Нийгмийн салбарын зарим эрэлттэй мэргэжлээр гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцагч Монгол улсын иргэнд олгох тэтгэлэг
Орон нутгийн их, дээд сургуульд суралцагчийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт	81872	Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчийн сургалтын байгууллагад суралцах сургалтын төлбөрийн 50 хувийн хөнгөлөлт .
Судалгааны татаас, грант	81873	Эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, их, дээд сургуулийн тэнхим эсвэл судлаачид, бизнесийн байгууллага, бизнес эрхлэгчид улсын болон орон нутгийн төсвөөс олгох судалгаа, хөгжүүлэлтийн татаас, грант, улсын захиалгат төслийн санхүүжилт. Судалгаа хөгжүүлэлтийн ангилалд багтахгүй судалгаа, шинжилгээнд олгосон санхүүжилт энд хамаарахгүй.
Судалгаа хөгжүүлэлт	81874	Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухаан технологийн сангийн хүрээлэн, төвийн үндсэн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслийн санхүүжилт энд хамаарна. Улсын захиалгат төслийн санхүүжилт энд хамаарахгүй. Судалгаа хөгжүүлэлтийн ангилалд багтахгүй судалгаа, шинжилгээнд олгосон санхүүжилт энд хамаарахгүй. Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухаан технологийн сангийн хүрээлэн, төвийн байнгын үйл ажиллагааны зардлыг 80101 Үндсэн үйл ажиллагааны ангилалд бүртгэхгүй, энэ ангилалд бүртгэнэ
Соёл:		
Театр, чуулгад гүйцэтгэлээр олгох санхүүжилт	81948	Аймаг, орон нутаг дахь театр чуулгын байгууллагын үйл ажиллагаа
Номын санд гүйцэтгэлээр олгох санхүүжилт	81949	Аймаг, орон нутаг дахь номын сангийн үйл ажиллагаа
Музейд гүйцэтгэлээр олгох санхүүжилт	81950	Аймаг, орон нутаг дахь музейн үйл ажиллагаа
Соёлын төвд гүйцэтгэлээр олгох санхүүжилт	81951	Аймаг, орон нутаг дахь соёлын төвийн үйл ажиллагаа
Биеийн тамир спорт		
Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих	82115	Спортын тэмцээн, дасгалын бүлэг, алхалтын клуб зэрэг багийн үйл ажиллагааг зохион байгуулж, хүмүүсийг хамтдаа идэвхтэй байхыг дэмжих, ажлын байранд дасгал хөдөлгөөн хийхийг дэмжих арга хэмжээ
Үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагаа	82116	Зөвхөн үндэсний хэмжээнд зохион байгуулагдах үйл ажиллагаа
Бусад спортыг дэмжих	82117	Үндэсний шигшээ багт хамаардаггүй спортын төрөлд олгох улсын төсвийн дэмжлэг санхүүжилтэд хамаарах зардлыг энэ ангилалд хамааруулна.

Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	82118	Насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үе-Үндэсний шигшээ багийн хэвийн үйл ажиллагааг хангах
Дотоодод зохиогдох олон улсын тэмцээн	82119	Дотоодод зохион байгуулагдах олон улсын чанартай, олон улсын оролцогчдыг хамруулсан тэмцээнийг зохион байгуулах
Спортын өндөр амжилтын шагнал, урамшуулал	82120	Олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал.

Жич: Төсвийн ангилалд шинээр нэмэгдсэн кодуудыг FISCAL програмд суулгасан тул төсвийн мэдээлэл оруулахаас өмнө Сангийн яамнаас өгөгдлийн баазыг авна уу.

Төсвийн зардлыг төлөвлөхдөө Төсвийн захирагч бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тохирох хөтөлбөр, түүний хүрэх үр дүн болон үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт төлөвлөн ирүүлнэ. Аливаа арга хэмжээний аль нэг эдийн засгийн ангилалд бөөн дүнгээр зардал төлөвлөхгүй байх, урьд нь бөөн дүнгээр төлөвлөсөн зардлыг зохих хөтөлбөр, арга хэмжээ-зориулалт, эдийн засгийн ангиллаар нь задалж төсөвт тусгах. Ингэснээр салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд бодлогын дүн шинжилгээ хийх, бодит мэдээллийг бүртгэх, төлөвлөлт-гүйцэтгэлийн уялдаа хангагдана;

Хөтөлбөрийн болон арга хэмжээний ангиллын “Ангилалдаагүй бусад” гэсэн хэсгийг сонгож төсвийн санал оруулахгүй байх. Хэрэв уг ангилалд санал оруулсан бол төсвийн төсөлд хянаж, тусгахгүй бөгөөд төсвийн орлого, эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалж төлөвлөсөн зарлагын санхүүжилтийг хойшлуулах, зардлыг бууруулах, эсвэл төсөвт тодотгол хийж бууруулах тохиолдолд энэхүү ангилал нь ач холбогдлоороо хамгийн сүүлд эрэмбэлэгдэхийг анхаарах;

Хөтөлбөрийн орон тооны мэдээллийг **ТМ-01** маягтын “Г” хэсэгт заасан ангиллаар төсвийн төлөвлөлтийн FISCAL программд оруулсны дагуу бэлтгэх;

ТМ-01 үндсэн маягт болон нэмэлт маягт (**НМ-01-10**)-ууд нь зөвхөн ТЕЗ-ийн түвшинд хийгдэх боловсруулалтыг шаарддаг тул төсвийн удирдамж түүний маягтуудыг доод шатны төсвийн захирагчдад шууд хуулбарлан хүргүүлэхгүй байхыг анхаарна уу. Харин эдгээр маягтуудаар төсвийн санал бэлтгэхийн тулд шаардагдах мэдээллийг доод шатны төсвийн захирагчдаас авах (орон тооны судалгаа, тэтгэвэрт гарах хүмүүсийн судалгаа, байгууллагын төсвийн санал гэх мэт) нь зүйтэй.

2.8 Төсвийн санал хүлээн авч хянах

Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсөв болон орон нутгийн төсөвт хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг дор дурдсан

хугацаанд хянаж Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэнэ.

Хүснэгт 3. Төсвийн төсөл бэлтгэх процесс

Хяналт болон төлөвлөлтийн процесс	Эхлэх болон дуусах хугацаа
Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсвийн саналыг хүлээн авч хянах	VII/25- VII/31
Жилийн төсвийн төсөлд инфляцын болон бусад бодлогын тохируулга хийх	VIII/01- VIII/10
Төсвийн саналыг олон нийтээр хэлэлцүүлэх	VIII/06- VIII/09
Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төслийг тус тус холбогдох бусад материалын хамт Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэх	VIII/10- VIII/15
ТЕЗ нартай 2025 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг хийж холбогдох тохируулгыг хийн, УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэх	VIII/15- VIII/30

Төсвийн Ерөнхийлөн захирагчид төсвийн төслийн саналаа бэлтгэхдээ маягтад заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд дээрх шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

3. ТӨСВИЙН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Төсвийн тухай хуулийн 28¹.1.1-т “төсвийн төсөл боловсруулахад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах”, 28¹.2.2-т “хэлэлцүүлгийг салбар бүрээр явуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 сарын 06 өдрийн 93 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу 2024 оны 8-р сарын 15-ны өдрийн дотор олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулна. Уг журамтай <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089516809531&showType=1> хаягаар орж танилцана уу.

Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад анхаарах асуудлууд:

- 3.1. Төсвийн тухай хуулийн 28¹.2.5-д олон нийтийн хэлэлцүүлэгт зориулж санал авах асуудлаар хялбаршуулсан танилцуулга боловсруулах гэж заасны дагуу ТЕЗ бүр **4_Төсвийн саналын товч танилцуулга**-аар төсвийн төслийн танилцуулгыг бэлтгэнэ.
- 3.2. Төсвийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журмын 2.8 дахь заалтын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах зардлыг салбарын батлагдсан төсвөөс санхүүжүүлнэ.
- 3.3. Дараах урьдчилсан хуваариар хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. (Хэлэлцүүлгийн оролцогчид болон хэлэлцүүлэх асуудлаас шалтгаалан хэлэлцүүлгийн товд өөрчлөлт орж болно.)

Хүснэгт 4. Олон нийтийн хэлэлцүүлгийн урьдчилсан хуваарь

Хэлэлцүүлгийн огноо	Салбар	Хариуцах яамд
2024.08.06	цахим хөгжил; харилцаа холбоо; гадаад харилцаа; хүнд үйлдвэр; уул уурхай; барилга; зам, тээвэр; эрчим хүч; бусад.	ЦХХХЯ, ГХЯ, УУХҮЯ, БХБЯ, ЗТХЯ, ЭХЯ, бусад
2024.08.07	боловсрол; шинжлэх ухаан; соёл; спорт; байгаль орчин; аялал жуулчлал;	БСШУЯ, СЯ, ОНБТСҮХ, БОАЖЯ
2024.08.08	хөдөлмөр; нийгмийн хамгаалал; хүнс; хөдөө аж ахуй; хөнгөн үйлдвэр;	ХНХЯ, ХХААХҮЯ
2024.08.09	эрүүл мэнд; хууль зүй; аюулгүй байдал;	ЭМЯ, ХЗДХЯ, БХЯ

- 3.4. Сангийн яамны цахим сайтуудаар нэгдсэн журмаар төсвийн төслийн саналуудыг байршуулж, хэлэлцүүлэгт танхимаар оролцогчдыг бүртгэлийг цахимаар хийнэ. Иймд 2025 оны төсвийн төсөл болон 2026-2027 оны төсвийн төсөөллийн саналын файлыг tusuv@mof.gov.mn хаягаар ирүүлнэ үү.
- 3.5. Сангийн яамнаас хэлэлцүүлгийн талаар нэгдсэн мэдээллийг холбогдох салбаруудад тухай бүр нь хүргүүлнэ.

4. ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР

4.1 Төсвийн үндсэн маягт буюу ТМ-01

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж байгаа бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилна. Удирдамжийн хавсралт файл [1.1_Төсвийн саналын маягт](#)-ыг бөглөхдөө дараах зүйлсийг анхаарах. Үүнд:

- 4.1.1 Урсгал болон хөрөнгийн зардлыг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөрөөр тодорхойлсон байх;
- 4.1.2 Хөтөлбөрийн төсвийн саналыг **ТМ-01** маягтад заасны дагуу “А” зардлын эдийн засгийн ангиллаар; “Б” зардлын зориулалт-арга хэмжээгээр; “В” санхүүжүүлэх эх үүсвэрээр задалж дунд хугацаагаар буюу 1-ээс 8 дугаар баганаар харуулсан байх;
- 4.1.3 Бүх хэсгүүдийн өөрчлөлтийн харьцуулалтыг 9, 10, 11 дүгээр баганаар харуулсан байх;
- 4.1.4 Төсвийн төслийг тухайн төсвийн жилийн батлагдсан орлого, зарлагын хязгаарт багтаасан байх (**ТМ-01** маягтын 5 дугаар багана);
- 4.1.5 Хэрэв урьдчилан төсөөлөх, төлөвлөх боломжгүй, түүнчлэн УИХ болон Засгийн газраас төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар баталснаас хойш үүссэн нөхцөл байдлын улмаас батлагдсан төсвийн хязгаараас давах, зайлшгүй авч үзэх шаардлагатай төсвийн

саналтай бол тооцооны төслийг **ТМ-01** маягтын **6** дүгээр баганад харуулах;

4.1.6 Хөтөлбөрийн хүрээнд ажиллах орон тооны мэдээллийг төрийн албан хаагчийн ангиллын дагуу маягт **ТМ-01** ийн “Г” хэсэгт заасны дагуу үнэн зөв гаргаж харуулах;

4.1.7 Хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах төсөв захирагчийн (төсвийн байгууллагын) төсвийн мэдээллийг **ТМ-01** маягтын “Д” хэсэгт холбогдох баганаар тусгаж харуулсан байх;

4.1.8 Хөтөлбөрийн хүрээнд ирэх он болон түүний дараагийн хоёр жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа зорилтуудыг **ТМ-01** маягтын “Е” хэсэгт товч тодорхой тусгана.

4.1.9 Зардлын тойм – Зардлын дүн шинжилгээ: **ТМ-01** маягтын “Ё” хэсгийг бэлтгэхэд дэмжлэг болгох зорилгоор нэмэлт тайлбар оруулж байна. Тухайн ТЕЗ-ийн багцын хувьд дунд хугацаанд салбарын бодлогын гол тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүнг хангахын тулд салбарын бодлого юунд чиглэж байгаа (ө.х. төсвийн хөрөнгийг юунд голлон зарцуулахаар төлөвлөж байгаа) талаар тайлбарлаж бичнэ. Тухайн багцын төсвийн суурь түвшинд өөрчлөлт оруулсан бол тэр талаар мөн бичнэ. Тухайн ТЕЗ-ын төсөв ямар гол хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хуваарилагдаж буй талаар, мөн нийт зардлын хувьд эдийн засгийн зардлын зүйл болон шилжүүлгүүдэд хэрхэн хуваарилагдсан, гол онцлох зүйлсийг дурдаж, энэ нь ямар бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой болохыг тайлбарлана.

Үр дүнгийн үзүүлэлтийг хангахад нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйлүүд тухайлбал, орон тоо, бусад гол орц /зардлын зүйлс/-ууд г.м. зүйлсийн талаар дурдаж, зарлага нь орон тооны хандлага, гүйцэтгэлтэй яаж уялдаж буйг тайлбарлана. Тодорхой зарлагын өсөлт анхаарал татах хэмжээнд хүртэл өөрчлөгдөж байгаа бол энэ нь юунаас болж өөрчлөгдөж буйг орц болон бүтээгдэхүүний гүйцэтгэлтэй уялдуулж тайлбарлах. Зардалд гол нөлөө үзүүлж буй хүчин зүйлс /зардал чиглүүлэгчид/ болон зардал, гарц /бүтээгдэхүүн, үйлчилгээ/ болон хөтөлбөрийн хоорондын уялдааг, дүн шинжилгээний хамт танилцуулах. Энэ хэсгийг дунджаар 2 хуудаст багтаан бичвэл зохимжтой. Дээрх хөтөлбөр, үр дүнгийн танилцуулгыг бичихэд дараах зүйлсийг харгалзан үзэх:

(a) Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хангахад дунд хугацаанд төсвийн зарцуулалт аль хөтөлбөр, бүтээгдэхүүнд голлон чиглэж буй талаар товч дурдах;

(b) Тодорхой гарц /бүтээгдэхүүн, үйлчилгээ/ хангахад гол хөтөлбөр болон зарлагын чиг хандлага, хүний нөөц болон бусад орц хэрхэн хувь нэмэр оруулах талаар дурдах;

(c) Засгийн газраас баталсан хязгаар нь гарцыг нийлүүлэхэд хэрхэн нөлөөлөх вэ, суурь түвшинд гарах өөрчлөлт, тэрхүү

өөрчлөлт гарахад хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлж оруулах;

- (d) Тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан гол хөтөлбөр болон орцын хувьд хангалтгүй хэмжээний төсөв хуваарилагдсан шалтгааныг тайлбарлах, дутагдсан санхүүжилт гарцын үзүүлэлтэд ямар нөлөө үзүүлсэн болон үүнийг ирэх жилийн төсвийн хувьд хэрхэн засаж, залруулах талаар оруулах;
- (e) Хүний нөөцийн болон бусад томоохон орцуудын өсөлтийн хувьд гарч буй өөрчлөлтийг дунд хугацааны төсвийн хүрээнд тайлбарлах.

4.1.10 Төсвийн хязгаараас давсан саналын үндэслэл, тайлбар, нотолгоог **ТМ-01** маягтын “Ж” хэсэгт товч тодорхойлсон байх. Хязгаараас давсан хэсгийн санхүүжилтийг ямар эх үүсвэрээс шийдвэрлэх ба ингэхдээ маягтын “З” хэсэгтэй уялдсан байдлаар тодорхойлох;

4.1.11 Нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдол бага гэж үзэж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах саналтай бол, түүнчлэн санхүүжилтийг нь бууруулах болон зогсоох хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлтийг юунд зарцуулах тухай саналаа **ТМ-01** маягтын “З” хэсэгт товч тодорхойлсон байх.

4.2 Төсвийн үндсэн маягтын нэмэлт буюу ТМ-01а

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүн, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх. ТЭЗ нар хүрэх үр дүнг тодорхойлохдоо “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан холбогдох хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг харгалзан үзнэ. Хэрэв “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тухайн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй бол хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг батлагдсан төсвийн хязгаарт багтаан тооцож, тодорхойлно. Ингэхдээ нэг хөтөлбөрт 3-с дээшгүй үр дүнг тодорхойлохыг анхаарна уу.

Түүнчлэн үр дүн болон шалгуур үзүүлэлт тодорхойлох аргачлалыг **1.2_ТМ-01а маягт бөглөх заавар** - аас танилцана уу.

4.3 Төсвийн удирдамжид дагалдсан төсвийн маягтуудын товчоо

Хүснэгт 5. Төсвийн саналын нэмэлт маягтууд

Маягтын нэр	Хүснэгтийн код	Маягт болон хүснэгтийн агуулга
1.1_Төсвийн саналын маягт	НМ-01	ТЕЗ-ийн харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлогын санал
	НМ-02	ТЕЗ-ийн төсвийн урсгал зарлагын саналын товчоо
	НМ-03	ТЕЗ-ийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн санал
	НМ-04	ТЕЗ-ийн шинээр ашиглалтад орох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбогдон гарах урсгал зардлын тооцоо
	НМ-05	ЭМД-ын шимтгэлийг нь төрөөс хариуцан төлөх иргэдийн тооцоо
	НМ-06 (ОН) НМ-06а (ОН) НМ-06 (УТ) НМ-06а (УТ)	Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдагчдын судалгаа
	НМ-07 НМ-07а НМ-07б НМ-07в	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн судалгаа
	НМ-08	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн тэтгэмж авах албан хаагчийн судалгаа
	НМ-09	ТЕЗ-ийн Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал
	НМ-10 НМ-10а	ОН-ийн сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмжийн судалгаа
1.2_ТМ-01а маягт бөглөх заавар		ТМ-01а маягтыг бөглөх заавар
2.1_ҮДСТ төсвийн саналын маягт_УТ		ХНХЯ, ХХААХҮЯ, СоЯ, БТСУХ, БШУЯ-ны ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөв боловсруулах маягт
2.2_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар_УТ		ХНХЯ, ХХААХҮЯ, СоЯ, БТСУХ, БШУЯ-ны ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөв боловсруулах маягт бөглөх заавар
3_Fiscal-B гарын авлага		Fiscal – B гарын авлага
4_Төсвийн саналын товч танилцуулга		Олон нийтээр хэлэлцүүлэх асуудлаар төсвийн саналын товч танилцуулга бэлтгэх загвар
5_ЖМТ асуулга ба төсвийн саналын маягт.		Туршилтын яамдад зориулсан Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн төсвийн маягт

4.4 Бусад

- 4.4.1 Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх;
- 4.4.2 Ажлын ачааллыг нягтруулах замаар одоо мөрдөгдөж байгаа орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталж, орон тоо, цалингийн санг төлөвлөх;

- 4.4.3 Бараа үйлчилгээний үнийг хамгийн сүүлд эрх бүхий байгууллагаас баталсан тарифаар, төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр тэтгэмжийн өсөлтийг тэгтэй тэнцүү байхаар тооцож ирүүлэх;
- 4.4.4 Олон улсын байгууллага, гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр салбарын хэмжээнд хэрэгжиж буй болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн орлого, зарлагын тооцоог нэмэлтээр хавсаргаж ирүүлэх;
- 4.4.5 Төсвийн байгууллагаас 2025 онд өндөр насны тэтгэвэрт гарахаар тооцсон хүмүүсийн тоог төсвийн төлөвлөлтийн Fiscal-B программд 80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг арга хэмжээ-зориулалтын ангилалд болон 46 кодтой **“нийт тэтгэвэрт гарагч”** нэмэлт мэдээллийн ангиллыг тус тус сонгон оруулах;
- 4.4.6 Төрийн албан хаагчийн орон тооны мэдээллийг энэ удирдамжид хавсаргасан **3_Fiscal-B гарын авлага**-д заасны дагуу төсвийн төлөвлөлтийн **Fiscal-B системд** шивж оруулах;

--o0o--